



WWF for a living planet®

RAMBOLL

Ramboll Natura AD

Сүрьеүүд

2008 оны 7 сар

Лист 13

АГУМАГА

XVIII дас

- Тогтвортой хөгжлийн боловсролын эргэн тойронд

XVIII дас

- Төвч мэдээ

ХУЧАС

- Тогтвортой хөгжлийн үндсэн асуудал

Хүудас

 - Багшийн цуглуулгад:

XVII

- Тархи сэргээгч дасгалууд



for a living planet

Далайн Баягаль хамгаалж сан (WWF)-түн
Монгол дахь хөтөлбөрийн газар
Амарын тудамж-4, Сүмбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар- 210620 ш/х-20A, Монгол улс.
Телефон: +976-11-311659;
Факс: +976-11-510237
E-mail: info@wwf.mn
Web site: www.wwf.mn
www.panda.org



Швейцарийн Олон Улсын Хөгжлийн хамтын Амшилгааны Агентлаг (SIDA)-ийн санхүүнийтээр энэ сонин хязалдэв.

Дугаар балтэрэн: Ц. Одгэрэл
Хийсэн: Е. Онон
А.Дэлгэрмээ
Хөхлөлийн хэлтэй: Г.Мянг-Эрдэнэ
Хөхлөснөн: Хиймээрийн хөхлөлийн гардар

...Хүн төрөлхтөний хамтын ажиллагааг бий болгож, харилцан бие
биенээ хүндэтгэж цэнхэр нудэн өлтийгээ хайрлан хамгаалах уу,
эсвэл веердийн махал төгсгалийг хүлээх уу, энэ бол

Бид харилцан ойлголцож бүхий л улс орон, үндэстэн, овог, аймаг амьдралынкаа хэв маягт үзэмж өөрчлөлтүүд хийж чадснаар зөв сонголтондоо жүрэх юм. Хүн тэрэлктенийг хөгжил нь илүү ихийг авах гэхээсээ илүү хүнэлэг байх ёстой гэдгийг бид ухамсарлах ёстой. Бидний мэдлэг, туршилага бүгдэд хүртээлтэй байх төдийгүй хүрээлэн буй орчинд үзүүлэх хор нэлвөгөө багасгах ёстой. Хүрээлэн буй орчны, эдийн засгийн, улс төрийн, нийтгүй болон итгэл үнэмшилийн асуудлууд өөр хоорондоо хамааралтайг бөгөөд хамтдаа бид шийдлүүдийг олж чадна.

21-р зүүрийг шүүдээр га, тогтолцоогой, тайлан ишгэлийн
дэлхийн дэвяаф хөгжлийнээд барилгын тажигчидээж
зарчиж нүүдлийн түншгэгэлэлтэй... түншгэгэлэл



Боловсрол соёл шинжлэх ухааны яамны дэргэдэх Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах тесел

Тогтвортой хөгжлийн боловсролын асуудал анх удаа боловсролын бодлогын хүрээнд сургалтын хөтөлбөрт тусгагдаж байна.

Манай орны ерөнхий боловсролын сургуулиуд 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих гэж байгаатай холбогдон 12 жилийн сургалтын хөтөлбөр боловсруулах теслийг БСШУЯ-аас хэрэгжүүлж, 13 баг ажиллаж байгаагийн нэг нь "Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр боловсруулах" баг юм. Багийн гишүүд нь бусад 12 багийн нарийн бичгийн дарга нар мен хамтран ажиллаж буй теслийн төлөөлөл оролцож байна.

Үйл ажиллагааны хүрээ нь:

- Математик, монгол хэл, байгалийн ухаан болон бусад бүх хичээлүүдийн хөтөлбөрт ТХБ-ын үзэл санааг тусгах зөвлөмжийг боловсруулах
- "Хичээлийн бус үйл ажиллагаа"-ны хөтөлбөрүүдэд (сонгон суралцах, иргэний боловсрол, теселт ажил) ТХБ-ын үзэл санааг тусгах
- хүний неөцийн чадавхийг дээшлүүлэх
- багшийн аргазүйн хөгжил
- хичээлийн хөгжил
- багшийн мэргжил дээшлүүлэх "сургууль төвтэй" шинэ тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах Цаашдаа БСШУЯ-аас гаргасан хөтөлберийн дагуу бусад багтай хамтран тодорхой анги, тодорхой хичээлүүдийн хувьд ТХБ-ын үзэл санааг хичээлийн киррикулимд тусгах чиглэлээр ажиллана.



Боловсрол Соёл Шинжлэх ухааны Яам, Азийн хөгжлийн банк

Боловсрол ядууралыг хамтад нь

Монгол улсын засгийн газар Азийн хөгжлийн банууны зээлээр "Боловсролын хөгжил-III" теслийг хэрэгжүүлж байна. Тесел нь бага, дунд сургууль, мэргэжлийн сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх замаар сургууль төгсөгчдийн ажлын байранд өрсөлдөх чадварыг сайжруулан улмаар ажил эрхлэлт болон орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр ажиллаж байна. "Боловсролын хөгжил-III" теслийн үйл ажиллагаа нь үндэсний хэмжээнд хэрэгжидэг бөгөөд ялангуяа орлого бага хэсгийхэнд илүү анхаарлаа хандуулан ажиллаж байна.



БСШУЯ ны харьяа Албан бус боловсрол зайндын сургалтын үндэсний төв

Албан бус боловсролын Гэгээрэл төвөөс мэдээлэлээ авна уу.

Ази – Номхон далайн бүсийн соёлын төв (ACCU)-тэй хамтран НҮБ-ын Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын 10 жилийн холбогдолтой (2005-2014) зарим бичиг баримт болон ТХБ-ыг албан бус замаар олгоход зориулсан сургалтын материалыг ТХБ-ын албан бус сургалтын хөтөлберийн хамт боловсруулан гаргасан.





- 4 гарын авлага:
Нишингэ бэлдэх,
Гялгар уут хаягдал мэн үү?, Хортон шавьж
устгах..., Хог хаягдалыг дахин ашиглаж
болов үү?
Эдгэр материалуудыг дуурэг, аймаг,
сумдын АББ-ын Гэгээрэл төвөөр
дамжуулан тараадаг.
ТХБ-ын 10 жилийн зорилтыг
хэрэгжүүлэх олон улсын загвар (орчуулга)
- 5 зурагт хуудас, (хэмжээ 350x500):
“Болгоомжил”, “Тамхи-чимээгүй дайсан”,
Таны бивийн жин хэвийн байна үү?, Хоол
хүнсний зохистой хэрэглээз, Элгээ
хамгаалья
- Амьдрах ухаанд суурилсан зруул мэндийн
боловсрол: БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх
сургалтын хетелбер



Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг (ГТХАН)

“Байгаль орчны мэдээлэл, сурталчилгаа ба байгаль орчны боловсрол”
тесел эхэллээ.

“Байгаль хамгаалал, байгалийн неөцийн тогтвортой менежмент” хетелberийн хүрээнд ГТХАН-ээс
“Байгаль орчны мэдээлэл, сурталчилгаа ба байгаль орчны боловсрол” теслийг шинээр хэрэгжүүлж эхлээд
байна. Төслийн зорилго нь хүмүүс байгалийн неөцийг ашиглах, байгаль орчинд хандах ухамсар, мэдлэгийг
дээшшуулжээд оршино. Төслийг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Нидерландын
засгийн газрын санхүүжилтээр ГТХАН хэрэгжүүлж байна. Монголын талаас хамтран хэрэгжүүлэгч нь
Байгаль орчны яам болно. Тесел нь 2008 оны 3 сард эхэлсэн ба 2010 оны 11 сар хүртэл үргэлжилнэ.
Тесел нь гурван тувшинд дараах гурван зорилттой.

1. Иргэдийн байгаль орчны талаархи ойлголт, мэдлэг дээшилсэн байна. (албан бус боловсролын хүрээнд)
2. Тогтвортой хөгжлийн боловсролын үндэсний кирриколимийг орон нутгийн (сургуулийн) түвшинд
тохируулан боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. (албан боловсролын хүрээнд)
3. Байгаль орчны мэдээлэл сурталчилгааг орон нутгийн түвшинд сайжруулах.

Байгаль орчин болон ТХБ-ын тулгамдсан асуудлаар Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутгийн
бүсийн сургуулийн багш нарын мэргжил дээшшуулж сургалтыг тус аймгуудын БСГ-ын мэргжилтэн наартай
хамтран зохион байгуулав. Хан Хэнтийн Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумдын
сургуулийн багш нарын “ОЙ” сэдэвт хичээлийн кирриколим боловсруулах уралдааныг БСШУЯ, БОЯ-тай
хамтран хэд хэдэн үе шаттайгаар зохион байгуулсан нь багш нарын бүтээлч санаачлагыг дэмжсэн, тэднийг
чадавхижуулэх үр дүнтэй ажил болжээ.



Швейцарын Хөгжлийн агентлаг: Цэлжилтийг сааруулах тесел (SDC)

Иргэдийн экологийн мэдлэгт хувь нэмэр болохоор бас нэг тесел

Цэлжилтийг сааруулах теслийн нэг хэсэг нь тогтвортой хөгжлийн талаарх боловсролын сургалт зохион
байгуулах замаар монголын залуучуудын экологийн талаарх мэдлэгийг улам сайжруулах, тэдний байгаль
орчинтой харьцах хандлагыг өөрчлөхэд чиглэнэ. Байгаль орчны боловсролын сургалтыг албан ба албан
бус гэсэн 2 хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ТХБ-ын үндэсний кирриколим боловсруулах үндэсний багийг мэргэшүүлэх ажлыг БСШУЯ-тай хамтран
зохион байгуулж байна. Ингэснээр албан сургалтаар сургачдын байгальд хандах хандлага, төлөвшлийг
өөрчлөх сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх юм.

Улаанбаатар хот, Ховд, Говь-Алтай, Баянхонгор зэрэг аймгуудын Боловсрол соёлын газартай хамтран нийт
24 сургуульд эко загвар сургууль байгуулах, орон нутгийн түвшний хичээлийн кирриколим боловсруулах
ажлуудыг хийж байна.

Тогтвортой хөгжлийн боловсролын эзлэхийн төслийн хөтөлбөрийн газар (МХГ)

Тогтвортой хөгжлийн боловсрол нь биологийн төрөл зүйлийг хамгаалахад чиглэгдэх нь

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын байгаль хамгаалах хөтөлбөрүүдийн хүрээнд ховор ан амьтан, тэдгээрийн амьдрах орчинг хамгаалах, тогтвортой байлгахад юуны өмнө байгаль орчны боловсрол олгох асуудал чухал юм.

Багшлах чадавхийг дээшлүүлэх зорилготойгоор 2004 оноос "Тогтвортой хөгжлийн боловсрол- Ногоон сургууль" төслийг хэрэгжүүлж Байгаль орчны боловсрол болон Тогтвортой хөгжлийн боловсролыг албан сургалтаар эзэмшүүлэх багш нарын аргазүйн служээг бий болгосон . Энэхүү багш нарын служээ нь тогтвортой хөгжилд нийцэх байгаль орчны боловсролыг сайжруулах, энэ талаархи ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалтын аргазүй, агууллын багцыг боловсруулах чиглэлээр ажиллаж байна. Мен байгаль орчны боловсролын системийг бэхжүүлэх зорилгоор баруун, баруун хойд бүсийн аймгуудыг хамарсан Алтай Соёны бус нутагт загвар сургуулиудын служээ байгуулсан. Загвар сургуулийн служээ нь сургуулийг бүхэлд нь тогтвортойгоор хөгжүүлэх зарчмыг боловсруулахаар ажиллаж байна.

Теслийн хүрээнд орон нутгийнхаа тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсрол" сэдэвт хичээлийн кирриколимыг эмхэтгэн гарын авлага хэвлүүлэн тараагдлаа.

БСШУЯ, БОЯ-тай хамтран зохион байгуулсан "Тогтвортой хөгжлийн төлөх боловсрол" сэдэвт үндэсний зөвлөгөөний эмхэтгэлийг та бугдийн гар дээр тавьж байна.

"Ирвэсэнд эзлтэй нутаг" төслийн хүрээнд Ховд аймгийн Чандмань, Манхан, Зэрэг, Дарви сумын сургуулиудад тогтвортой хөгжлийн боловсролыг загварчлахаар төвлөрж байна.

ТОВЧ МЭДЭЖ

Говь-Алтай аймагт 2008 оны 5 сарын 2 - ны өдөр Боловсрол Соёлын газраас ЕБС-ын багш нарын дунд "Тогтвортой хөгжлийн боловсрол" сэдвийн хүрээнд багшийн ур чадварын уралдаан болж өнгөрлөө. Уралдаанд Дарви, Цогт, Шарга, Тонхил, Дэлгэр, Бугат, Эрдэнэ, Хөхморьт, Бигэр зэрэг сумдын багш нар оролцсон бөгөөд "Орчны эрүүл ахуй", "Усны зохистой хэрэглээ", "Хог хаягдлыг дахин ашиглах боломж", "Цөлжилт", "Хөрсний бохирдол" зэрэг сэдвээр хичээлийн хөтөлбөр боловсруулав. Багш нарын ур чадвар, хичээлийн зорилго, зорилтыг тодорхойлсон байдал, агууллын багтаамж, түвшин интеграци, аргын сонголт хэрэглээ, хүүхдээр мэдлэг бутээлгэж хөгжүүлж буй байдал, сургалтын хэрэглэгдэхүүн сонголт, ашиглалт, хичээлийн үнэлгээ зэрэг хэд хэдэн шалгуураар үнэлж дүгнэв. Үүнд:

- 1-р байрыг I сургуулийн газарзүйн багш Б.Үүрцайх
- 2-р байрыг II сургуулийн газарзүйн багш Н.Дагиймаа, Бигэр сумын биологийн багш Ц.Цэвээндулам
- 3-р байрыг Эрдэнэ сумын физикийн багш П. Нямдаваа нар тус тус зээллээ.

Говь-Алтай аймгийн БСГ-ын аргазүйч Ц. Цэцэгмаа

Увс аймгийн сумдын ЕБС-ийн "Байгаль хамгаалах" сурагчдын сайн дурын клубын ўйл ажиллагааг идэвхжүүлж, байгалийн неецийг зохистой ашиглах хамгаалахад иргэд, хүүхэд заплуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2008 оны 3-р сарын 24, 25-нд "Дэлхийн өв - Залуу үеийнхэний гар" сэдэвт сургалт, 3-р сарын 26 -ны өдөр "Байгаль бидний гар" сурагчдын чуулга уулзалтыг зохион байгууллаа. Сургалт, уулзалтанд оролцогч багш, сурагчид "Байгаль хамгаалах" клуб 2007 оны хичээлийн жилд хийсэн ажлаа бусдадаа танилцуулж, нэгнээсээ суралцан шинэ санаа авч, харилцан туршлага солилцлоо.

Тогтвортой хөгжлийн үндсэн асуудал

Ирээдүйнхээ хэрэгшээг хангах нехшийг хомсдуулахгүйгээр өнөө үеийнхний хэрэгшээг хангах нь хойч ирээдүйдээ барих бидний үүрэг мен. Энэхүү үүрэгээ сайн биелүүлэхэд хүн төрөлхтөн тогтвортой хөгжлийн 8 гол асуудал анхаарлаа хандуулж байна.

1. Хүний нөөцийн асуудал

8,000,000,000
8,000,000,000
8,000,000,000
8,000,000,000
8,000,000,000



- Дэлхийн хүн ам 1999 онд 6 миллион байсан багаад 2025 он гэхэд 8 миллион болно.
- Хүн ам хамгийн хурдацтай хөгжж байгаа бус нутаг бол дэлхийн бөмбөрцөгийн өмнөд хагас буюу Африк, Ази, Латин Америкт байна.
- Дэлхийн бөмбөрцөгийн хойд, өмнөд хагасыг харьцуулахад нэг хүнд ноогох нөөцийн зарцуулалтын түвшин зурс ялгаатай байдаг.
- Эрүүл мэнд, боловсролын түвшин, нийгмийн нөхцөл дэлхийн бөмбөрцөгийн хойд, өмнөд хагаст мөн л эрс ялгаатай байна.

2. Хүнсний аюулгүй байдлын асуудал



- 1950-иад оноос хойш дэлхий дээр мах, сүүн бүтээгдэхүүн гурав дахин ессен ч өлслөлөн өргөн тархалттай хөвзэр байна.
- Үрийн шинэ төрөл, химийн бордоо, хортон шавьжны устгал, сайжруулсан усжуулалт зэрэг хөдөө аж ахуйн шинэлэг аргууд нь хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна. Харин үүнд шаардагдах зардлын хэмжээ нь ихэнх жижиг фермерүүдийн хувьд хэтэрхий их байна.
- Хөдөө аж ахуйн шинэлэг аргууд нь хурээлэн буй орчинд хортой нелөө үзүүлж эргээд хүний эрүүл мэндэд ч хохирол учруулсаар байна.
- Үрсэлгээний олон янзын арга, хортон шавьж устгал нь их хэмжээний ус, химийн бодис шаарддаг.
- Химийн бордоо, хортон шавьж устгач ихээр хэрэглэснээр хөрс, усны химийн бохирдолыг ихэсгэж улмаар хоол хүнсэн дэх химийн бодисыг хэмжээг нэмэгдүүлдэг.
- Усжуулалт нь хөрсний давсжилт, шүлтжилтэнд нелөөлдөг.



3. Хотжилтийн асуудал

- Дэлхийн хүн амын 50%-иас илүү нь хот суурин газар амьдарч байна
- Өмнөд хагасын ихэнх хотуудад хүн ам сүүлийн 30 жилд дөрөв дахин илүү нэмэгджээ.
- Хүн амын төвлөрөл хэт ихэссэнээр хотын дэд бүтэц түүний үйлчилгээ шаардлага хангахаа болив.
- Хотжилтой холбоотой хамгийн чухал асуудлууд бол ажилгүйдэл, ядуурал, эрүүл орчин, эрүүл мэндийн асуудлууд болно.



4. Эрчим хүчний асуудал

- 2025 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээ 1980 оныхоос 40%-иас илүү хэмжээгээр өсч болно.
- Хамгийн их хэрэглэгддэг эрчим хүчний нөөц нь:
 - Газрын тос, байгалийн хий гэх мэт чулуужсан түлш;
 - усны эрчим хүч;
 - цөмийн эрчим хүч;
 - өмнөд хагасын орнуудын хүн амын ихэнх нь эрчим хүч гарган авдаг гол эх үүсвэр болох биомасс түлш буюу мод, ургацын үлдэгдэл, өтөг бууц зэрлийг хэрэглэдэг.
- Дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний дэнгэж 21% нь нөхөн сэргээгдэх эрчим хүч болно.
- Чулуужсан түлшийг хэрэглэснээр 4 үндсэн асуудал гарч ирж байна. Үүнд:
 - нүүрсхүчлийн хийн ялгаралтаас болж уур амьсгалын өөрчлөлт бий болсон (хулэмжийн хийн нелөө);
 - шаталтын явцад хүхрийн давхар исэл, азотын давхар исэл ялгарсанаар хотын агаарын бохирдол, хүчинлэгжилт бий болно.
 - нөөцийн хорогдол
 - олон улсын зөрчилдөөн.
- Цөмийн эрчим хүч нь мөн дараах асуудлуудыг бий болгоно. Үүнд:
 - Бүтээгдэхүүн болон хог хаягдлын салбарт ажиллагсадын эрүүл мэнд эрсдэлтэй
 - Олон нийт эрүүл мэндийн хувьд эрсдэлтэй
 - Гэнэтийн аюул осол ихтэй
 - Маш хатуу чанга хамгаалалт шаардлагатай



Тогтвортой хөгжлийн үндсэн асуудал

5. Аж үйлдвэрийн асуудал

- Үйлдвэржилт нь эдийн засгийн есөлтийг авчрах боловч хөдөө орон нутгаас хүн амын шилжилтийг хот руу чиглүүлж агаар, газар, гол мөрөн, тэнгисийн усны бохирдлыг нэмэгдүүлнэ.
- Өмнөд хагасын орнуудын аж үйлдвэрлэлжилтийн хэв загвар нь яг адилхан бөгөөд хүрээлэн буй орчин, нийгмийн талаар ижил асуудлуудтай тулгарсан байдаг



- Зардал, худалдаа, технологийн ялгаатай байдлаас болоод хөгжж буй орнуудын үйлдвэржилтийн бохирдол, химийн хортой хог хаягдлаа шийдэх асуудал нь үйлдвэржсан орнуудыг бодвол дутагдалтай байдаг.

6. Экосистем ба биологийн төрөл зүйлийн асуудал

- Дэлхий дээрх биологийн төрөл зүйлийн тоо хэмжээ 5-30 сая хүртэл байна гэсэн тооцоо байдаг. Тухайлбал сүүлийн хоёр зуу шахам жилийн хугацаанд л гэхэд 17 зүйл баавгай, 5 зүйл чоно, үнэг, 4 зүйл муур, 10 зүйл зэрлэг үхэр, хонь, ямаа, герөөс зэрэг туроотан, 5 зүйл зэрлэг адuu, тахь, илжиг туурайтан амьтад эргэлт буцалтгүйгээр сенежээ.

Биологийн төрөл зүйлийн мөхөл нь дан ганц байгаль орчны төдийгүй, янз бурийн улс үндэстний байгалийн неөц баялагтай холбоотой зан үйл, сусг бишрэл, ард түмний уламжлалт соёл, амьдралын хэв маяг, гоо сайхны сэтгэлгээ зэрэг нийгэм, эдийн засгийн олон зүй тогтолцыг хөнддөг, серег үр дагавартай үйл явц болохыг эрдэмтэн судлаачид тогтоосон байдаг.



8. Хүрээлэн буй орчны доройтол ба зөрчилдөөний асуудал

- Хүрээлэн буй орчны доройтол нь газар нутгийн хэт их ашиглалт, ган гачиг, уур амьсгалын дулаарал зэрэг хүчин зүйлүүдээс болдог. Энэ нь ёлсгалын, хомсдолыг гүнзгийруулж цаашдаа нийгэмд зөрчилдөөн, үймээн самууныг ихэсгэдэг.
- Цэнийн дайны аюул нь бидэнд урьд өмнө тохиолдож байгаагүйгээр экосистемийн сүйрлийг авчирна.
- Хөгжил буурай хүрээлэн буй орчны асуудалтай улс оронд цэргийн зориулалттай хэт их зардлыг багасгах



7. Бүх нийтэд нээлттэй хамтын өмчийг зохицуулах асуудал

- Антартик, далай тэнгис, сансар огторгуй зэрэг "дэлхийн хамтын өмч"-ийн нэг хэсэгт улс орон жигд хариуцлага хүлээн.
- Хэт их ашиглат үүнд загасчлал болон далай тэнгисийн эргийн усны бохирдол зэрэг байгаль орчны асуудлууд эрс хэмжээгээр нэмэгдсээр л байна.
- Дэлхийн хэмжээнд загас олборлолт байх ёстой хэмжээнээсээ жилдээ 30 сая тонноос илүү байдаг гэсэн тооцоо байна.
- Далай тэнгисийн усиг бохирдуулж байгаа гол нехцел нь хот суурин газрын бохир ус, үйлдвэр хөдөө аж ахуйн хаягдал, далайн усанд асгарсан газрын тос бусад химийн хортой хог хаягдал болно.
- Антартикийн менежмент нь Антартикийн Олон Улсын гэрээгээр зохицуулагдаж байдаг. Гэрээнд гарын үсэг зурсан улс орнуудын өмнө тулгараад буй гол асуудлууд бол уул уурхайн олборлолт бүхий газрын хог хаягдал ёсен нэмэгдэж, Антартикийн талаарх шийдвэр гаргалтад ихэнх улс гурнуудийг орхигдуулсан явдал юм.





Тогтвортой хөгжлийн боловсролын асуудал анх удаа боловсролын бодлогын хүрээнд сургалтын хөтөлбөрт тусгагдаж байгаа бөгөөд тодорхой анги, тодорхой хичээлүүдийн хувьд ТХБ-ын үзэл санааг хичээлийн киррикулимд хэрхэн тусгах талаар багш нартдаа зөвлөмж болгох үүднээс ЮНЕСКО-ийн "Тогтвортой ирээдүйд сургацаая, сурцаая" багш нарын боловсролын программаас та бүхэндээ цувралаар хургж байна. Энэ удаа математикийн хичээлд ТХБ-ын үзэл санааг яаж тусгах талаар, дараа дараагийн дугаартаа бусад хичээлүүдтэй хэрхэн холбогдож болох талаар толилуулах болно.

$$\operatorname{tg} 2\alpha = \frac{2 \operatorname{tg} \alpha}{1 - \operatorname{tg}^2 \alpha},$$

$$\cos \frac{\alpha}{2} = \pm \sqrt{\frac{1 + \cos \alpha}{2}},$$

Үндсэн сэлэв/ асуудал

Экосистемийг үзэлэх/хэмжих.

Экологийн бусийг тооцох/тодорхойлох/ тогтоох
Хэмжигдэх боломжгүй үнэт зүйлс

Суурь ойлголт ойлголт

Өнөө үед байгалийн өөрчлөлт нь хүний гар хүрээгүй, технологийн нелөөнд өртөөгүй хүрээлэн буй орчны зарим бүс нутгуудад хүртэл үзэгдэж байна. Хүрээлэн буй орчны энэхүү өөрчлөлт нь хүний нелөөнөөс үдэлтэй эсвэл байгалийн жам ёсны үзэгдэл эсэхийг тогтоох нь ихэнх тохиолдолд төвөгтэй байдаг. Тиймээс бодит байдлыг нарийн хэмжиж тодорхойлох нь дэлхий цаг уурын өөрчлөлтийн учрыг ойлгох хамгийн чухал алхам болно. Үүнд байгаль орчны байдлын (газрын гадарга г.м) өөрчлөлтийг (усны ургсал г.м) хэмжиж, мэдээллийн орон зай (ой модны устал) болон цаг хугацааны (жил тутам всеж буй цөлжилтийн хэмжээ г.м) хувьд боловсруулах шаардлагатай юм. Хүрээлэн буй орчны нелөөллийн үнэлгээнд тухайн орчинд явагдаж буй үйл ажиллагааны үр ашиг, зардлыг тооцох ёстой. Гэсэн хэдий ч мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэлэх боломжгүй олон зүйл байдаг. Тэгвэл ийм үнэт зүйлийг хэрхэн үнэлэх вэ?

Үйл ажиллагаа

- Математикийн хичээлээр хүрээлэн буй орчны өөрчлөлтийн түвшин, үнэн бодит хэмжээ, өөрчлөлтэй хамааралтай тоо баримт, хүрээлэн буй орчны хэмжих боломжтой үнэлэлтэнд анхаарч ажиллах ёстой. Жишээ нь: Эдийн засгийн хувьд буурай болон баян улсуудыг сонгож авах хэрэгтэй.
- Дээрхи улсуудын нэг хүнд ноогдох жилийн эрчим хүчний хэрэглээ, нүүрстөрөгчийн ялгаруулалтын хэмжээг харьцуул.
- Мөн хөдөө аж ахуй, үйлдвэрийн салбар, хотын хүн амын жилийн усны хэрэглээг тодорхойл.
- Үүнийгээ усны хэрэглээний неөцтэй харьцуулж, улс тус бүрт жилдээ хэдий хэмжээний ус ногоон бүс, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хэрэгцээнд зориулагдаж буйг тодорхойлж, нэг хүнд ноогдох хэмжээг тооц.
- Анги танхим, сургууль, гэр бүлийнхээ зерчим хүчнийхээ хэрэглээг хэмжих үйл ажиллагааг зохион байгуул. Жишээ нь: Хэр их цахилгаан хэрэглэсэн, хэр их цаас, хуванцар ашиглаж хаясан гэх мэт. Хүрээлэн буй орчинд үзүүлсэн нелөөллийг энергийн нэгжид шилжүүлж мөнгөн дунгзэр илэрхийл.
- Өөрийн хамгийн чухал үнэлдэг 10 зүйлийг нэрлэ. Тэдгээрийг мөнгөн дунгзэр илэрхийлэх гэж оролд. Жишээ нь: Хэрэв та зарах гэж буй зүйлээ худалдан авах авах байсан бол ямар үнэ төлөх байсан бэ? Харин ямар зүйлийг үнэлж чадахгүй, үнэлэх боломжгүй байна вэ?
- Ой мод ямар үнэтэй бол? Ойн экосистемийн төрөл зүйлийг тодорхойл. Түүнээс ямар зүйлс нь мөнгөн дунгзэр илэрхийлэгдэх боломжгүй байна вэ? гэдгийг ярилцаарай.

Тархи сэргээгч дасгалаас:

1. Асуулт: Том уу, жижиг үү зөвзэл дунд зэрэг үү?

Дорж, Сарнай, Дэлгэрмаа нар кино үзэхдээс уух юм авах болжээ. Тэд ундаа зарж буй хүүхдэд "бид том, жижиг, дунд зэргийн хэмжээтэй ундаанууд авмаар байна гэхдээ би томоор савласан ундааг нь авахгүй" гэж Сарнай хэлжээ. Тэгтэл "би чамайг томоор савласан ундааг авах юм байна гэж бодсон" гэж дунд зэргээр савласан ундааг авах гэж буй хөвгүүн хэлжээ.

Хол нь ямар хэмжээний ундаа авах хүчинчлийн байсан бэ?



2. Асуулт: Гайхамшигт тав

Таван ширхэг 2 орлогуудлан харуу 5-ийг яаж тарах вэ? Математикийн үйлдлүүдийг ашиглан таван ширхэг 2-ийн хариу 5-ийг яаж гаргасныг дор харуулжээ.

$$2 \times 2 \times 2 + 2 / 2 = 5$$

Дараах 3 эгнээ тоонд математикийн үйлдлүүдийг ашиглан хариу нь 5 гарахаар байрлуулаарай.

a. $33333=5$

b. $44444=5$

c. $55555=5$



3. Асуулт: Гайхамшигт дервэлжин

Доорхи хоосон дервэлжингүүдийг эгнээ, багана, диагналь байдлаар нэмэхэд нийлбэр нь 30 гарч байх тоонуудыг бэглэнэ үү.

12		16
		8

4. Асуулт: Тоог нөхөж бичээрэй.

Дараах тоон дарааллыг сайн ажиглаад хоосон зайд ямар тоог нөхөн бичиж болохыг олоорой.

4 7 11 18 29 47 _____ 123 199 322

5. Асуулт: Хямдраг

Дэлгүүрт компьютерын барааны хямдрал явагдаж нэг компьютерыг 25%-иар хямдруулжээ. Хэдэн долоо хоногийн дараа компьютерын загварыг түүний анхны үнэд бариулах хэрэгтэй болжээ. Үүний тулд үнийг хэдэн хувь есгэх вэ? (Компьютерыг дурын үнээр сонгоорой)

